

## Стандарт

# E10 – Усны хэрэглээ чанарын хяналт

2008 оны 12 сар

### Нууц баримт бичиг

Энэ баримт бичиг нь Рио Тинто компанийн ЭМААБО-ны зохиогчийн эрхэд хамаарах өмч бөгөөд Рио Тинто Группын компаниудын хувьд нууц мэдээллийг агуулна.

© Рио Тинто 2008

Группын үйл ажиллагаа:	Рио Тинто компанийн Эрүүл мэнд, Аюулгүй ажиллагаа, Байгаль орчны хэлтэс
Салбар:	Байгаль орчин
Хүчинтэй болох огноо:	2009 оны 1 – р сарын 1
Төлөв байдал:	Эцсийн хувилбар
Хувилбарын дугаар:	2
Баримт бичгийн дугаар:	STE10
Баталсан:	Брюсь Келли
Бэлтгэсэн:	Адриан ван Тондер

## Агуулга

<b>Хамрах хүрээ</b>	<b>3</b>
<b>Хөтөлбөрийн ерөнхий бүтэц</b>	<b>3</b>
<b>Хянан засварласан түүх</b>	<b>7</b>

## E10 – Усны хэрэглээ чанарын хяналт

### Хамрах хүрээ

Энэхүү стандартыг Рио Тинтогийн удирдан явуулж буй хайгуул, судалгааны ажлаас эхлээд уурхайг хаах түвшинд явагдаж байгаа бүхий л бизнес нэгжүүд, үйл ажиллагаанд мөрдөгдөнө. Үүнд компаний төв буюу захиргааны оффис, төслийн талбайн гадна орших лабораторийн барилга байгууламжууд багтана. Уг стандартыг бүх төрлийн, эх үүсвэртэй усны менежментийн үйл ажиллагаанд мөрдөгдөнө.

**Зорилго:** Тухайн стандартын зорилго нь Рио Тинтогийн үйл ажиллагаанд хамаарах буюу ойр орчмын усны нөөц болон экосистемд үр дүнтэй, аюулгүй, баттай хяналт тавих, хамгаалахад оршино. Уг зорилгыг хэрэгжүүлэхэд усны нөөц, түүний орон зайн болоод түр хугацааны харилцан хамаарал, усны нөөцийн байрлал, оролцогч талуудын усны сав газрыг ашиглах хэрэгцээ, шаардлагын талаар тодорхой ойлголттой байх шаардлагатай. Эдгээр мэдээлэл баримт нь тухайн нийгэм, байгаль орчин, иргэдийн хэрэглээ, эдийн засаг зэрэг усны менежментийн нэгдсэн стратегийн арга барилыг боловсруулан гаргах үндэслэл болно.

### Холбогдох бусад баримт бичиг:

- ЭМБООААЧ-ын удирдлагын тогтолцоо (буюу РТБС буюу SAP ашигладаггүй үйл ажиллагааны хувьд E1 Байгаль орчны удирдлагын системийн стандарт)
- Усны хэрэглээ ба чанарын хяналтын удирдамж
- Рио Тинтогийн усны стратеги
- Хүчиллэг урсацыг урьдчилан тооцож, хянах стандарт
- Аюултай бодис ба бохирдлыг хянах стандарт
- Эрдэсийн хог хаягдлын менежментийн стандарт
- Рио Тинтогийн хаалтын стандарт
- Ил уурхайн уулын ажлын стандарт загвар, уурхайн налууугийн менежмент ба бусад холбогдох удирдамжууд
- Ил уурхайн уулын ажлын стандарт загвар, хаягдал чулуулгийн ба бусад холбогдох удирдамжууд
- Легионеллын өвчний тухай удирдамж
- Нийгэм, байгаль орчны жилийн судалгаа явуулах зааварчилгаа

### Хөтөлбөрийн ерөнхий бүтэц

#### 1. Төлөвлөлт

1.1 Хассан (тавигдах шаардлагыг 1.2-р хэсэгт оруулсан).

1.2 Үйл ажиллагаа явуулж буй талбайн ус цуглуулах сав газар дахь усны нөөц, экосистемд үзүүлэх нөлөөллийн, байгалийн нөөцийн нийт хэрэглээний талаар зохих ойлголттой болгох шаардлагатай. Үүнд усны урсгалын эхэн болон адагт

урсацаас доош орших хэрэглэгчид, оролцогч талуудын зүгээс одоо тавьж буй болон ирээдүйд тавих хүсэлт, шаардлага, экосистемийн бүрэн бүтэн байдлыг хадгалахад шаардагдах усны урсацын горим, чанар зэргийн талаарх ойлголт, мэдээлэл багтана.

- 1.3 Төслийн талбайн усны хэрэглээтэй холбоотой гарч болзошгүй эрсдлийг хянахад тохиромжтой, цаашдын усны хэрэглээний шаардлага, цаг уурын өөрчлөлтийн урьдчилсан таамаглалыг гаргах, усны менежментийг сайжруулах боломжийг олж тогтоох замаар төслийн талбайн усны баланс боловсруулж, түүнийг тогтмол шинэчилж байна. Ноцтой эрсдэл гарч болзошгүй тохиолдолд бохирдол үзүүлэх бодисын уусалтын балансыг мөн боловсруулна.
- 1.4 Шинэ бүтээн байгуулалт явуулах, байгаа барилга байгууламжийг өргөтгөх, өөрчлөх, нөхөн солих болсон үед ус цуглуулах сав газрын чанар, хэвийн үйл ажиллагаа, ашиглалт, гадаргын болон хөрсний усны экосистем, усны нөөцийн бүрэн бүтэн байдал зэргийг хамгаалах зорилгоор үйл ажиллагааны өөрчлөлтийг удирдан зохион байгуулах арга хэмжээ нэвтрүүлнэ.
- 1.5 Усны нөөцийг хамгаалах тухай төрөөс тавьж буй эрхзүйн шаардлага байхгүй, хангалтгүй, эсвэл бүрхэг утга агуулгатай бол усны хэрэглээ, шавхалт, ашигласан усыг зайлуулах, хаях ба усны чанарт тавих шалгуур үзүүлэлтийг гаргах шаардлагатай бөгөөд түүнийг хэрэгжүүлснээр гадаргын ба гүний усыг хамгаалах боломжтой болно. Уг шалгуур үзүүлэлтийг үйл ажиллагаа хариуцсан ерөнхий захирал албан ёсоор батлах шаардлагатай бөгөөд энэхүү үзүүлэлт нь олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн доод хэмжээ, удирдамж, зааварчилгаа, арга зүйд нийцсэн байна.
- 1.6 Төслийн талбайн усны менежменттэй холбоотой эрсдлийг бууруулах, үйл ажиллагааг сайжруулах боломжтой үндсэн нэгж, хэсгүүдэд зориулсан тодорхой зорилтыг гаргана. Эдгээр зорилтуудад хүрэх бодит арга хэмжээ авах шаардлагатай бөгөөд зорилтуудыг төслийн бизнес төлөвлөгөөнд тусгасан байна.
- 1.7 Уг стандартын зорилго болоод холбогдох эрх бүхий байгууллагын дүрэм журам, тавьсан шаардлагад нийцүүлэхийн тулд усны менежментийн үйл ажиллагааг тодорхойлсон Усны менежментийн төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлнэ. Уг төлөвлөгөөг төслийн талбайн бизнес төлөвлөгөөтэй уялдуулж, үйл ажиллагаа, нийгэм, байгаль орчны нөхцөл байдлаас хамааран хянан шинэчилж байх ба наад зах нь дөрвөн жил тутам хянан шинэчлэх шаардлагатай.

## 2. Хэрэгжилт ба ашиглалт

- 2.1 Усны менежменттэй холбоотой ажил үүрэг болон хариуцлагыг тодорхой хуваарилж өгсөн байна. Уг хуваарилалт байгууллагын бүтцийг хангалттай төлөөлсөн байх бөгөөд төлөвлөгөөний хэрэгжилтийг хянах үүрэгтэй албан тушаалтнуудыг мөн тогтоосон байна.
- 2.2 Ус татах, хадгалах, цэвэршүүлэх, зайлуулах барилга байгууламжийг зохих норм, стандартыг үндлэслэн зохион байгуулах, барих ба ашиглах шаардлагатай. Мөн дараах шаардлага хангана ажиллана. Үүнд:

- a) Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах үед эрсдлийн үнэлгээг хийж уг барилга байгууламж ба үйл ажиллагаатай холбоотой гарч болзошгүй эрсдлүүдийг (тухайлбал хүчтэй шуурга зэрэг хэвийн үйл ажиллагаа,

бүтээгдэхүүний чанарт сөргөөр нөлөөлөх эрсдлүүд) тогтоож засч залруулах арга хэмжээ авах бэлэн байдлыг хангана.

- b) Барилга угсралтын ажлыг холбогдох стандарт, хууль эрх зүйн шаардлагын дагуу төдийгүй тогтоосон бүхий л ноцтой эрсдлийг бууруулах боломжтой хэмжээнд гүйцэтгэх шаардлагатай.
- c) Барилга байгууламжийн ашиглалтыг батлагдсан зураг төслийн шалгуур үзүүлэлт, ашиглалтын дүрэм журмын дагуу явуулах бөгөөд усан мандал, экосистем болон уст давхаргыг хамгаалах ажлыг эхлүүлэх, хариу арга хэмжээ авах шалгуур үзүүлэлтийг уг байгууламжийн ашиглалтад тусгасан байна.

2.3 Дараах гарч болзошгүй үйл явдал тус бүрт онцгой байдлын болон үйл ажиллагааг тогтвортой явуулах ажлын төлөвлөгөө боловсруулна. Үүнд:

- a) ган гачиг;
- b) үер;
- c) томоохон ус цуглуулах, хадгалах барилга байгууламж нурах;
- d) хаягдал бохир усны гэнэтийн асгаралт.

Онцгой байдлын үед авах арга хэмжээ нь Уурхайн хаягдлын менежментийн стандартад заасанчлан ижил төстэй томоохон хаягдал цуглуулах байгууламжуудад тавих шаардлагад нийцүүлэн удирдан зохион байгуулна.

### 3. Ажлын гүйцэтгэлийг хэмжих

3.1 Урьдчилан тогтоосон бүхий л аюулыг дэлгэрэнгүй шалгах, баталгаажуулах зэрэг ажлыг хамарсан аюулгүй ажиллагааны үзлэг хийх журмуудыг ус хадгалах томоохон барилга байгууламжинд боловсруулж хэрэгжүүлнэ. Эдгээр журмын агуулга нь Уурхайн хаягдлын менежментийн стандартад заасанчлан томоохон хаягдал цуглуулах байгууламжинд хийх үзлэг, шалгалт, ажил үүргийн зохион байгуулалтанд тавьсан шаардлагад нийцүүлэн боловсруулсан байна.

3.2 Хяналт шинжилгээ, шалгалт явуулах, засч залруулах арга хэмжээний хөтөлбөрийг хэрэгжүүлж дараах үр дүнд хүрэхийг эрмэлзэнэ. Үүнд:

- a) үйл ажиллагааны хяналтад дэмжлэг үзүүлэх;
- b) тавьсан зорилго, зорилт, хууль эрх зүйн шаардлагад нийцүүлэн ажиллах байдлыг шалгах;
- c) бодит болон урьдчилан тооцоолсон усны балансыг харьцуулан үзэх;
- d) ус болон ууссан бодисын баланс, ус цуглуулах сав газар ба гүний усны загварыг шинэчлэх;

- e) гүний ба гадаргын усанд үзүүлэх тооцоолсон ба бодит нөлөөллийг харьцуулан үзэх;
- f) байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг үнэлэх;
- g) боломжтой бол ашиглалтаас ус цуглуулах болон сав газарт, усны бусад хэрэглэгчдэд үзүүлсэн нийт нөлөөллийг үнэлэх;
- h) ажлаа бусдад тайлагнах шаардлагыг ханган ажиллах;
- i) төслийн талбайн усны балансад өндөр ач холбогдолтой усан сан, дамжуулах хоолой зэрэгт тоолуур суурьлуулан, усны хөдөлгөөн, хуримтлал, нөөцийг хянана. Үүнд дахин ашиглах усыг цуглуулах сан орно.

Төслийн талбай дахь устай холбоотой гарч болзошгүй бүхий л эрсдэл, үйл ажиллагаа, ажлын үйл явц төдийгүй байгаль орчин, усны чанар, түүний хэрэглээнд томоохон өөрчлөлт орсон эсэхээс шалтгаалан хяналт шинжилгээний ажлыг явуулах давтамжийг тогтооно.

## 4. Хянан засварласан түүх

Хувилбар	Хүчинтэй болох огноо	Бэлтгэсэн	Баталсан	
1	2005 оны 6 сар	Аделино Табоада	Гүйцэтгэх удирдлагуудын зөвлөл	
Хувилбар	Хянан засварласан огноо	Хянан засварласан	Баталсан	Өөрчлөлт оруулсан шалтгаан
2	2008 оны 12 сар	Адриан ван Тондер	Брюсь Кэлли	Ашиглалтын багаас өгсөн зөвлөмжийг тусгаж, ЭМААБОЧ – ын удирдлагын тогтолцоонд нийцүүлэн өөрчилсөн.
	2012 оны 10 сар	Мани Д.Альтерио		Оюу Толгойн үйл ажиллагаанд хэрэгжүүлэх зорилгоор лого-г хамтатгав. Агуулгад өөрчлөлт оруулаагүй болно.

Уг баримт бичиг нь Оюу Толгой ХХК-ий Эрүүл мэнд, Аюулгүй ажиллагаа, Байгаль орчны Удирдлагын тогтолцооны гүйцэтгэлийн стандарт болох "E10 Усны хэрэглээ чанарын хяналт"-ын монгол хэл рүү орчуулсан хувилбар болно. Энэхүү баримт бичгийн албан ёсны хувилбарыг ОТ Проспект цахим хуудаснаас авах боломжтой. Хэвлэсэн буюу хяналтаас гарсан хувилбарыг ашиглахын өмнө баримт бичгийн хяналтын түүх дэх огноог ОТ цахим хуудсан дах хамгийн сүүлийн электрон хувилбартай харьцуулан үзэж сүүлийн хувилбар мөн эсэхийг шалгана уу.

Оюу Толгой ХХК уг баримт бичгийг Монгол хэл рүү нягт нямбай, үнэн зөв орчуулахад хичээнгүйлэн ажилласан болно. Гэвч орчуулгын элдэв хүндрэлээс шалтгаалж, Англи болон Монгол хувилбарын хооронд ямар нэг зөрүү гарч болохыг үгүйсгэх аргагүй юм. Хэрэв орчуулгын үнэн зөвтэй холбоотой ямар нэгэн эргэлзээ төрвөл баримт бичгийн албан ёсны хувилбар болох англи хувилбарыг (E10 Water use and quality control )уншина уу.